



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 0/31

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3, 6.5.5, 6.5.19 дэх заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.1.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалын хэрэгцээнд ашиглах “Албан ажлын, дуудлагын суудлын, хөдөө ажлын автомашин ашиглах журам”-ыг нэгдүгээр, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалуудын албан ажлын болон дуудлагын, хөдөө ажлын автомашины жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Хавсралтаар батлагдсан журамд нийцүүлэн БХЯ, харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, ангиудад дуудлагын суудлын болон тусгай үйлчилгээний автомашин ашиглах журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга (бригадын генерал Д.Ганхуяг), Зэвсэгт хүчний Жанжин штаб (бригадын генерал С.Ганбямба)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

САЙД

Г.САЙХАНБАЯР



Батлан хамгаалахын сайдын 2023 оны

2.. дугаар сарын 2.-ны өдрийн
23... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“АЛБАН АЖЛЫН, ДУУДЛАГЫН СУУДЛЫН, ХӨДӨӨ АЖЛЫН
АВТОМАШИН АШИГЛАХ ЖУРАМ”



Нэг. Нийтлэг үндэслэл.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалын (цаашид “Хэрэглэгч” гэх) албан ажлын болон дуудлагын суудлын, хөдөө ажлын автомашиныг албан хэрэгцээнд ашиглахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.1. Батлан хамгаалахын сайдын тушаалаар БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалуудын албан хэрэгцээнд ашиглагдах албан ажлын, дуудлагын суудлын, хөдөө ажлын автомашины жагсаалтыг тогтооно.

Хоёр. Албан ажлын болон дуудлагын суудлын автомашин ашиглах.

2.1. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалын албан ажлын, дуудлагын суудлын автомашиныг зөвхөн ажлын өдрүүдэд 08.30-17.30 цагт хоногийн 40 км-ийн лимиттэйгээр ашиглана.

2.2. Албан ажлын болон дуудлагын суудлын автомашиныг дугаарын хязгаарлалттай, баяр, амралтын өдрүүд болон ажлын бус цагаар ашиглахыг хориглоно.

2.3. Ажлын зайлшгүй шаардлагаар энэхүү журмын 2.2-т заасан өдрүүдэд автомашин хэрэглэх тохиолдолд яамны Төрийн нарийн бичгийн дарга, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч даргаас зөвшөөрөл авсан байна.

2.4. Яамны Төрийн нарийн бичгийн дарга, ЗХЖШ-ын Материал, техникийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Зэвсэгт хүчний 089 дүгээр анги нь дуудлагын болон хөдөө ажлын автомашиныг үйлчилгээнд гаргана.

2.5. Албан ажлын болон дуудлагын суудлын автомашин хэрэглэгч нь дараах үүрэг хүлээнэ.

2.5.1. хэрэглэгч нь дуудлагын суудлын автомашиныг тогтоосон хугацаанд зориулалтын дагуу батлагдсан маршрутаар ашиглах;

2.5.2. захиалгаар тогтоосон лимит, гүйлтийн нормыг мөрдөх;

2.5.3. зөвхөн үйлчлүүлэгчийн журмаар ашиглах, замын хөдөлгөөний дүрэм зөрчихийг шаардахгүй байх;

2.5.4. ашиглалтын явцад зам тээврийн осол зөрчил, техникийн saat алгаралтад гарсан тохиолдолд Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба, үйлчлэгч ангид яаралтай мэдэгдэх, шуурхай арга хэмжээ авхуулах;

2.5.5. автомашин ашигласан тухай бүртээ замын хуудаст тэмдэглэл хийх;

2.5.6. зөвхөн диспетчерээр дамжуулан автомашиныг дуудаж ашиглах;

2.6. Дуудлагын суудлын автомашинаар үйлчлэгч анги нь дараах үүрэг хүлээж үйлчилгээ үзүүлнэ;

2.6.1. хэрэглэгчийг захиалгын дагуу ээлж дараатайгаар, батлагдсан лимитийн хүрээнд тогтоосон цагт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан автомашин, мэргэжлийн жолоочоор үйлчлэх;

2.6.2. хэрэглэгч Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн диспетчерээр дамжуулан, дуудсан автомашиныг үйлчилгээнд гаргах;

2.6.3. машин ашиглалтыг цаг тухай бүрд нь үнэн зөв хөтөлж, хэрэглэгч, дээд

шатны байгууллагыг мэдээллээр хангах;

2.6.4.хэрэглэгчээс гаргасан санал, гомдол, хүсэлтийг холбогдох журмаар шийдвэрлэх;

2.6.5.жолооч нартай замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гарсан шийдвэр, эрх зүйн бусад актыг биелүүлэх, сурталчлах, судлуулах, осол хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах;

2.6.6.техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангаагүй, улсын бүртгэл, техникийн үзлэг тооллогод хамрагдаагүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байх, техникийн бэлэн байдлыг хангах;

2.6.7.гүйлтийн норм, батлагдсан лимит дууссан автомашиныг дараагийн эрх нээгдэх хүртэл шууд зогсоох;

2.6.8.хэрэглэгчийн буруутай үйлдлийн талаар яамны Төрийн нарийн бичгийн даргад мэдэгдэж холбогдох арга хэмжээг авхуулах;

2.6.9.албан ажлын болон дуудлагын суудлын үйлчилгээнд хот, суурин газарт 2500м³ хүртэл хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжтай, овор хэмжээ бага автомашин ашиглана;

Гурав. Дуудлагын суудлын автомашиныг захиалах

3.1. Хэрэглэгч нь автомашин хэрэглэх захиалгыг албан бичгээр гаргаж, ажилд гарахын өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө яамны Төрийн нарийн бичгийн дарга, ЗХЖШ-ын Материал, техникийн газрын даргаар батлуулж, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид хүргүүлнэ. Хэрэв автомашины захиалгыг 16.00 цагаас хойш өгсөн тохиолдолд тус анги хариуцлага хүлээхгүй.

3.2.Тогтоосон хугацаанд захиалга ирүүлсэн хэрэглэгчийн захиалгад дурдсан огноо, явах чиглэлийг тодотгож, дуудлагын автомашиныг ээлж дараалал тогтоон хуваарь хийн, үйлчлэгчид хүргүүлэх ажлыг Зэвсэгт хүчний 089 дүгээр анги хариуцна.

3.3.Зөвхөн гэнэтийн зайлшгүй ажил гарсан тохиолдолд үйлчлэгч анги автомашиныг хуваарь харгалзахгүйгээр гарган ажиллуулж болно. Энэ тухай яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЗХЖШ-ын Материал, техникийн газарт яаралтай мэдэгдэнэ.

3.4.Хэрэглэгч хуваарилагдсан автомашиныг зөвхөн ангийн диспетчерээр дамжуулан дуудаж ашиглана. Хэрэв үүнийг зөрчсөн тохиолдолд тус автомашиныг ангийн байрлалаас гаргахгүй.

Дөрөв. Хөдөө ажлын суудлын болон тусгай зориулалтын автомашиныг ашиглах.

4.1.Хөдөө ажлын суудлын автомашиныг хотын төвөөс 80 км түүнээс алслагдмал зайд явж, ажил үүрэг гүйцэтгэхэд урьдчилан өгсөн захиалгын дагуу хуваарийн дарааллаар ашиглана.

4.2.Хөдөө ажлын автомашины жолооч нь Улаанбаатар хотоос гарахдаа (80км түүнээс алслагдмал зайд) Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанд техникийн бэлэн байдлыг шалгуулж, замын хуудсанд тэмдэглэл хийлгэнэ

4.4.Тусгай үйлчилгээний дуудлагын автомашинуудыг зөвхөн албан ажилд зориулалтын дагуу ашиглана.

Тав. Автомашин ашиглалтын тооцоо.

5.1.Хэрэглэгч автомашин ашигласан тухай бүрдээ Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 дүгээр тушаалаар батлагдсан “Жолоочийн тооцооны хуудас”-д явсан зайд, ашигласан хугацаа,

дараагийн ажилд дуудсан цаг, минутыг тэмдэглэж, гарын үсгээр баталгаажуулна. Дараагийн ажилд дуудсан хугацааг тэмдэглээгүй тохиолдолд уг автомашиныг үргэлжлүүлэн гаргаж үйлчлэхгүй.

5.2.Өдөр тутмын машины оролт, гаралт, ашиглалтын тооцоог тухайн өдрийн машины хуваарийг үндэслэн, диспетчер хяналт тавьж, ажиллана.

5.3.Ангийн ашиглалтын инженер, албадын дарга нар сар бүрийн 1 дүгээр долоо хоногт өмнөх сарын гүйцэтгэлийг нэг бүрчлэн гаргаж яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЗХЖШ-ын Материал, техникийн газарт танилцуулна.

5.4.Дуудлагын автомашины машин ашиглалтын тооцоог улирал бүр нэгтгэн дараа улирлын эхний сарын шуурхай зөвлөгөөн, мэдээллийн цагаар холбогдох бүрэлдэхүүнд танилцуулах ажлыг яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЗХЖШ-ын Материал, техникийн газар хариуцаж, хэрэгжүүлнэ.

5.5.Сарын гүйлтийн норм, батлагдсан лимит дууссан автомашиныг дараагийн эрх нээгдтэл шууд зогсоно.

Зургаа. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.

6.1.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр захиалгын дагуу дуудлагын автомашинаар үйлчлээгүй, ажил ноцтой хохироосон буруутай албан тушаалтанд Цэргийн сахилгтын дүрмийн холбогдох заалтын дагуу зохих хариуцлагыг тухай бүр нь хүлээлгэнэ.

6.2.Тус журмыг зөрчсөн, зориулалтын бусаар хэрэглэсэн, жолоочид буруу шаардлага тавьсан хэрэглэгчийн автомашин хэрэглэх асуудлыг БХС-ын тушаалаар 6 сар хүртэл хугацаатайгаар түдгэлзүүлэх ба анги, салбаруудын дуудлагын автомашиныг мөн хүртэл хугацаагаар хураан авч, ашиглалтыг зогсоно. Хэрэв шаардлагатай бол буруутай этгээдэд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

6.3.Энэхүү журмаар тогтоосон ашиглалтын хугацааг хэтрүүлсэн автомашиныг холбогдох аймаг, нийслэл, дүүргийн Замын цагдаагийн цагдаагийн хэлтэс, тасагтай хамтран журамлах ажлыг эрх үүргийнхээ хүрээнд Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ дүнг холбогдох албан тушаалтнуудад бичгээр танилцуулж, мэдэгдэнэ.

Долоо. Журмын хэрэгжилтэд хяналт тавих

7.1.Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЗХЖШ-ын Материал, техникийн газар мэргэжлийн удирдлагаар хангана. Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба шаардлагатай хяналт, шалгалт явуулна.

7.2.БХЯ, харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын автомашины ашиглалтын байдалд тогтмол хяналт тавьж ажиллах ба шаардлагатай үед яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЗХЖШ-ын Материал, техникийн газар, Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албатай хамтран үзлэг, шалгалт явуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллана.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалахын сайдын 2023 оны

1. дугаар сарын 1-ны өдрийн

131. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**БХЯ, ЗХЖШ, ТӨРЛИЙН ЦЭРГИЙН КОМАНДЛАУУДЫН АЛБАН АЖЛЫН
ДУУДЛАГЫН СУУДЛЫН, ХӨДӨӨ АЖЛЫН ЗОРИУЛАЛТААР ХЭРЭГЛЭХ
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

№	Хэрэглэгчийн Автомашин хэрэглэх албан тушаалтан, зохион байгуулалтын нэгж	Автомашины				
		Загвар	Дугаар	Өдрийн лимит /км/	Жилийн лимит /км/	
1	2	3	4	5	6	
Нэг. Батлан хамгаалах яам						
1.1. Албан ажлын автомашин						
1	Батлан хамгаалахын Дэд сайд	Хьюндай Соната-DN8	00-21 ЦАБ	40	10560	
2	Төрийн нарийн бичгийн дарга	Хьюндай Азера	00-20 ЦАБ	40	10560	
1.2. Дуудлагын суудлын автомашин						
3	Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгач	Хьюндай Соната-LF	00-28 ЦАБ	40	10560	
4	Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар	Хьюндай Азера	00-24 ЦАБ	40	10560	
5	Төрийн захиргааны удирдлагын газар	Хьюндай Соната-7	00-30 ЦАБ	40	10560	
6	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Хьюндай Азера	00-23 ЦАБ	40	10560	
7	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Хьюндай Соната-7	00-22 ЦАБ	40	10560	
8	Гадаад хамтын ажиллагааны газар	Хьюндай Соната-7	00-25 ЦАБ	40	10560	
9	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	Хьюндай Элентра	00-29 ЦАБ	40	10560	
10	БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ аж ахуйн хэлтэс	Реноулт Дастер	03-46 ЦАБ	40	10560	
1.3. Хөдөө ажлын автомашин						
1	БХЯ-ны Хөдөө ажлын автомашин	Ниссан Патрол Y62	01-02 ЦАБ		36000	
2		Ланд-200	01-03 ЦАБ		36000	
3		Ланд-200	01-20 ЦАБ		36000	
4		Лексус-570	01-23 ЦАБ		36000	
Хоёр. Зэвсэгт хүчний Жанжин штаб						
2.1 Албан ажлын автомашин						

1	ЗХЖШ-ын дарга	Хьюндай Соната-DN8	00-01 ЦАБ	40	10560
---	---------------	--------------------	-----------	----	-------

2.2. Дуудлагын суудлын автомашин

1	ЗХЖШ-ын I орлогч дарга	Хьюндай Соната-LF	00-02 ЦАБ	40	10560
2	ЗХЖШ-ын орлогч дарга	Хьюндай Азера	00-03 ЦАБ	40	10560
3	ЗХЖШ-ын ахлагч	Гранджеер DX	00-15 ЦАБ	40	10560
4	Бодлого, стратегийн төлөвлөлтийн газар	Хьюндай Соната-7	00-05 ЦАБ	40	10560
5	Ажиллагааны удирдлагын газар	Хьюндай Соната-7	00-06 ЦАБ	40	10560
6	Материал, техникийн газар	Хьюндай Соната-LF	00-04 ЦАБ	40	10560
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар	Хьюндай Соната-7	00-09 ЦАБ	40	10560
8	Сургалт бэлтгэлийн газар	Реноулт Дастер	00-16 ЦАБ	40	10560

2.3. Хөдөө ажлын автомашин

1	ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн албан ажлын хэрэгцээнд	Ланд-200	01-00 ЦАБ		36000
2		Ланд-200	01-11 ЦАБ		36000
3		Ланд-200	01-18 ЦАБ		36000
4		Ланд-200	01-06 ЦАБ		36000
5		Ланд-76	00-11 ЦАБ		36000
6		Ланд-76	01-28 ЦАБ		36000
7		Ланд-76	01-24 ЦАБ		36000
8		Ланд-76	01-25 ЦАБ		36000

Гурав. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал

3.1 Дуудлагын суудлын автомашин

1	Хуурай замын цэргийн командаагч	Реноулт Дастер	06-01 ЦАБ	40	10560
2	Хуурай замын цэргийн командаалалын штабын дарга	Хьюндай Соната-7	06-02 ЦАБ	40	10560

3.2 Хөдөө ажлын автомашин

1	Хуурай замын цэргийн командаалалын албан ажлын хэрэгцээнд	Ланд-76	06-00 ЦАБ		36000
---	---	---------	-----------	--	-------

Дөрөв. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал

4.1 Дуудлагын суудлын автомашин

1	Агаарын цэргийн командаагч	Хьюндай Соната-LF	10-01 ЦАБ	40	10560
---	----------------------------	-------------------	-----------	----	-------

4.2 Хөдөө ажлын автомашин

1	Агаарын цэргийн командаалалын албан ажлын хэрэгцээнд	Ланд-76	10-03 ЦАБ		36000
---	--	---------	-----------	--	-------

Тав. Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлал

5.1 Дуудлагын суудлын автомашин

1	Тусгай хүчний цэргийн командлагч	Ланд-76	13-00 ЦАБ	40	10560
5.2 Хөдөө ажлын автомашин					
1	Тусгай хүчний цэргийн командлалын албан хэрэгцээнд	Ланд-76	13-01 ЦАБ		36000
Зургаа. Зэвсэгт хүчний Киберь аюулгүй байдлын цэргийн командлал					
6.1 Дуудлагын суудлын автомашин					
1	Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч	Ренуалт Дастер	16-00 ЦАБ	40	10560
Долоо. Барилга, инженерийн цэргийг удирдах газар					
7.1 Дуудлагын суудлын автомашин					
1	Барилга-инженерийн цэргийн удирдах газар	Соната-7	17-00 ЦАБ	40	10560
7.2 Хөдөө ажлын автомашин					
1	Барилга, инженерийн цэргийн удирдах газрын албан хэрэгцээнд	Ланд-200	01-05 ЦАБ		36000

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ